

“ХҮРЭЭ ГУЧИН АЙМГИЙН СУРГУУЛЬ, СУРГАЛТЫН УЛАМЖЛАЛ” ИЛТГЭЛИЙН ТОВЧЛОЛ

Энэхүү илтгэлийн зорилго нь монголын бурхны шашны сургууль, сургалтын уламжлал орчин үед хэрхэн уламжлагдан буйг Зүүн хүрээ “Дашчойлин хийд”-ийн жишээн дээр харуулахыг зорилоо. Учир нь Зүүн хүрээ “Дашчойлин хийд” маань монголын шашны төв Хүрээ гучин аймгийн орыг нь залгамжлан үйл ажиллагаагаа явуулж буй хийд билээ. Иймээс илтгэлийнхээ хүрээнд доорхи 3 зүйлийн тухай товч өгүүлэхийг хичээх болно.

1. Монголын бурхны шашны сургууль, сургалтын тойм
2. Хүрээ гучин аймгийн шашны сургууль, сургалтын уламжлал
3. Зүүн хүрээ Дашчойлин хийдийн шашны сургалт

Нэг. Монголын бурхны шашны сургууль, сургалтын уламжлал

Монголын бурхны шашны сургууль хийгээд сургалтын уламжлалыг Монгол оронд дэлгэрэн хөгжиж байсан бурхны шашны үе үеийн дэлгэрэлтүүдтэй харгалзуулан авч үзэх нь зүйтэй болов уу. Иймээс Монголын бурхны шашны сургууль, сургалтыг доорхи байдлаар тоймлон хэлж болохоор байна. Үүнд:

1. Бурхны шашны эхэн үеийн дэлгэрэлтийн шашны сургууль, сургалтын уламжлал
2. Бурхны шашны дунд үеийн дэлгэрэлтийн шашны сургууль, сургалтын уламжлал
3. Бурхны шашны хожуу үеийн дэлгэрэлтийн шашны сургууль, сургалтын уламжлал

Хоёр. Хүрээ гучин аймгийн шашны сургууль, сургалт

Өндөр гэгээн Занабазар богд 1651 онд хурал мөргөлийн анхны долоон аймгаа байгуулсан бөгөөд төд удалгүй 1654 онд Хэнтий уулын өвөрт “Риво-гэжай-гандан-шаддүвлин” хэмээх анхны хүрээгээ байгуулжээ. Түүнээс хойш хүрээ 20 гаруй удаа нүүдэллэж, улмаар сүүлчийн буйр болох Хүй мандалд сууршинаас хойш 30 аймаг болтлоо өргөжин тэлсэн ба “Хүрээ гучин аймаг” хэмээн алдарших болов. Их хүрээ нь Зүүн хүрээ, Гандан гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэж байв.

Гандан. Далхын дэнж дээр байрлах Ганданд буддын гүн ухааны Дашчойнпэл, Гунгаачойлин, Идгаачойнзинлин хэмээх гурван дацан, Ү Богдын байгуулсан Диданповрон ордон, Бадам Ёго дацан, Ламрим дацан, 80 тохой Мигжэд Жанрайсигийн сүмүүд тус тус байрлаж байв.

Зүүн хүрээ. Зүүн хүрээнд Батцагаан Цогчин дуган, Эмч нарын дацан, Жүд дацан, Зурхайн дацан, Дэчингалбын дацан, Майдрын дацан, хүрээ гучин аймгын хурал номын дуганууд, Богдын ордон дэргэдэх сүмүүд байрлаж байв. Эдгээр дацан сургуулиуд хийгээд хурал номын газруудад судар тарнийн номлол бүтээл, дорно дахины их бага арван ухааныг ерөнхийлөн ба чиглэл чиглэлээр нь гүнзгийрүүлэн үзэж судалдаг байв.

Мөн Зүүн хүрээнд эм, зурхай, хэв, сийлбэр, манж, соёмбо, сав, шар, монгол, ланз үсэг, лав зураг зэргийн эрдэмүүдийг нарийвчлан сургадаг “Есөн зүйлийн сургууль” хэмээх нэртэй уламжлалт сургалтыг Шанзодбын яамнаас эрхлэн явуулдаг байжээ.

Гурав. Зүүн хүрээ Дашчойлин хийдийн шашны сургалт

Мөн 1998 онд байгуулагдсан "Зүүн хүрээ" шашны коллежийн сургалт нь манай хийдийн шашны сургалтын салшгүй хэсэг болсон билээ. Иймээс "Зүүн хүрээ" коллежийн сургалтыг тоймлон хүргэж байна.

Оо́й ёёёаа нь Буддын гүн ухаан судлал, Эх бичиг судлал, Шашин судлал, Монгол-Төвөд хэл бичиг судлал хэмээх үндсэн чиглэлүүдээр сургалтын үйл ажиллагаагаа эрхлэж байна. Бид энэхүү үндсэн чиглэлийнхээ хүрээнд одоогоор доорх сургалтын ажлаа эрхэлж байна.

1. Сүсэгтэн олонд □□□□□□□□ шаш□□ □□□□□□ мэдлэг олгоход чиглэгдсэн "Зөв амьдрах ухаан" □□□□□ □□□□□□□□ 3 шатлалтай сургалт
2. Буддын шашны ерөнхий эрдмийн суурь мэдлэг эзэмшүүлэх 2 жилийн сургалт
3. Буддын шашны дээд боловсрол олгох "Буддын гүн ухаан судлал", "Эх бичиг судлал"-ын 4 жилийн сургалт

Мөн манай хийдээс жил бүр тонтмол явуулдаг сургалт шашны зан үйлүүдээс дурьдвал:

- 45 хоногийн хайлан
- Хүрээ цам
- Хүрээ Майдар эргэх
- Жилийн дүйчэн өдрүүдийн бусад шашны зан үйлүүд болно.

Мөн тус хийд нь жил бүрийн Хүрээ Майдар эргэх зан үйлийг тогтмол зохион байгуулж цаашид Их хүрээнд байсан Майдар дуганы хамт сэргээн бүтээх их үйлсийг өрнүүлж байгаа билээ.